



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/7/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 173.

танай _____ ны № _____ т

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын 1 хөтөлбөр 8 арга хэмжээний хүрээнд нийт 1,128.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,025.5 сая төгрөгийг зарцуулж, 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай гэж үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь ОНХС болон бусад эх үүсвэрээс шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг орлого авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6326050168

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	316,902,335.0	343,209,714.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,150,505,887.4	2,539,731,812.1
	Нийт хөрөнгийн дүн	2,467,408,222.4	2,882,941,526.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,467,408,222.4	2,882,941,526.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,467,408,222.4	2,882,941,526.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,652,545,716.0	1,742,337,824.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,547,946,046.4	1,324,129,520.4
	Үйл ажиллагааны үр дүн	1,104,599,669.6	418,208,303.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	8,920,000.0	3,230,000.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,097,579,669.6	415,533,303.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,369,828,552.8	2,096,371,261.2
	Тайлант оны үр дүн	1,097,579,669.6	415,533,303.8
	Эцсийн үлдэгдэл	2,096,371,261.2	2,882,941,526.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,231,654,087.0	1,064,031,168.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,231,654,087.0	1,064,031,168.0
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,025,450,943.1
	Урсгал зардал	-	1,025,450,943.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,061,920,500.0
	Орон нутгийн төсвөөс	-	1,058,340,500.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	3,580,000.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 100.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын залрууллаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжтэй 100.9 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн нь УСНББОУС-17, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 59.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 2.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 56.7 сая төгрөгийн 3 албан шаардлага, 0.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг хэмжээний 19.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3.4 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Төсвийн хөрөнгөөр 1.6 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл авч зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор орон нутгийн төсвийн орлого болгох.

2. Сумын ЗДТГ-ын даргын 2025 оны А/20 дугаар тушаалаар сумын 4 багийн Засаг дарга нарт хээрийн эрээн хувцсаар хангахад 0.9 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор орон нутгийн орлого болгох.

3.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.9 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1-т “Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу төсвийг зориулалтын дагуу зарцуулж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 15-ны дотор биелэлт ирүүлэх

2. Жилийн эцсийн тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Эд хөрөнгийн дотоодын

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, журмын дагуу тооллогыг үнэн зөв, чанартай явуулах, биелэлтийг 2026 оны 07 дугаар сарын 20-ны дотор биелэлт ирүүлэх

3 Туслах аж ахуй болох 17.3 сая төгрөгийн дансны үнэтэй малыг гэрээ хийн маллуулдаг ч гэрээг дүгнээгүй, ашиг шимийн тооцоо хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, үндсэн үйл ажиллагааны зардлаас хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: зөрчлийг таслан зогсоож, холбогдох хуулийн дагуу үндсэн үйл ажиллагааны зардлаас хөрөнгө зарцуулахгүй байх, малчинтай байгуулсан гэрээг дүгнэх, ашиг шимийн тооцоо хийж, холбогдох нотлох баримтын бүрдлийг хангаж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор биелэлт ирүүлэх

4. Засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж 16.5 сая төгрөг, нэг цэгийн үйлчилгээний засварын 20.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг цахимаар зарлаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана", Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг таслан зогсоож, холбогдох хуулийн дагуу худалдан авах ажиллагааг цахимаар зарлаж хэвшүүлэх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор биелэлт ирүүлэх

3.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 92 нэр төрлийн нийт 683.6 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй нь Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам, аймгийн ИТХ-ын 2024 оны 25/08 дугаар тогтоолтой нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах.

1. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: "Си ти эс ХХК"-ий 2024 оны санхүүгийн программын төлбөр 0.5 сая төгрөгийг тайлант онд шилжүүлсэн ч өглөгөөр тусгаж тайлагнаагүй нь НББ-ийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.",

Төсвийн тухай хуулийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, тайлан бүртгэлд тусгадаг байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн	1	100,880.0			1	100,880.0	1	100,880.0				
Дүн	1	100,880.0	0	-	1	100,880.0	1	100,880.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Си ти эс ХХК"-ий 2024 оны санхүүгийн программын төлбөрийг тайлант онд шилжүүлсэн ч өглөгөөр тусгаж тайлагнаагүй	1	450.0					1	450.0				
Засаг даргын нөөц хөрөнгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт бусаар зарцуулсан	1	2,934.4			1	2,934.4						
Туслах аж ахуй болох малыг гэрээ хийн маллуулдаг ч гэрээг дүгнээгүй, ашиг шимийн тооцоо хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	17,315.0			1	17,315.0						
ЗДТГ-ын тооллогын комисс тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй байна	1	-			1	-						
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлээгүй	1	-					1	-				
Дүн	5	20,699.4	0	0	3	20,249.4	2	450.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	-	0	-	0	-	0	-
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	1	1,522.0	1	1,522.0				
Сумын 4 багийн Засаг дарга нарт хээрийн эрэн хувцсаар хангасан	1	924.0	1	924.0				
ЗДТГ-ын тоног төхөөрөмж, нэг цэгийн үйлчилгээний засварыг худалдан авах ажиллагааг цахимаар зарлаагүй	1	36,478.0			1	36,478.0		
Дүн	3	38,924.0	2	2,446.0	1	36,478.0	0	-
Нийт дүн	3	38,924.0	2	2,446.0	1	36,478.0	0	-

-oOo-